

## **НИСЛЭГИЙН ШИНЖЭЭЧ БОЛОН ТЕХНИКИЙН ШИНЖЭЭЧ**

### **Байгууллагын нэр:**

Зам, тээвэр хөгжлийн яамны Нислэг техникийн осол, зөрчлийг шинжлэн шалгах алба

**Ажлын байрны нэр:** Нислэгийн шинжээч -2, техникийн шинжээч -1

### **Тавигдах шаардлага:**

- Олон улсын иргэний нисэхийн байгууллага /ICAO/-ын Doc 9756, 1 дүгээр боть, 2 дугаар бүлгийн 2.4.3 хэсэг.
- НТОЗШША-ны дүрэм.

### **Шинжээч нь дараах шаардлагыг хангасан байна:**

- Мэргэжлийн нисгэгч, агаарын хөлгийн инженер мэргэжилтэй, мөн шинжээчийн сургалтанд хамрагдсан нисэхийн дээд боловсролтой магистр цолтой, дадлага туршлага бүхий боловсон хүчин байна;
- Нисэхийн салбарт 5.2.1-т дурьдсан чиглэлээр 10-15 жил ажилласан туршлагатай, шинжлэн шалгах ур чадварыг эзэмшсэн, мэргэжлийн магистр цолтой байх;
- Нисэхийн үндсэн чиглэлийн мэдлэг чадвартай, хүний хүчин зүйл зэрэг нисэхийн бусад бүрэлдэхүүн хэсгүүдийн хоорондын харилцан хамаарлын талаар мэдлэгтэй байх.

### **Бүрдүүлэх материал:**

- Төрийн албан хаагчийн анкет /2019 онд батлагдсан маягтын дагуу/
- Иргэний үнэмлэхийн хуулбар
- Дипломын хуулбар
- Мэргэжлийн үнэмлэхийн хуулбар
- Мэргэжлийн дагуу хамрагдсан сургалтын сертификатын хуулбар
- Ажил байдлын тодорхойлолт /өмнө нь ажиллаж байсан байгууллагаас/
- Цагдаагийн ерөнхий газрын тодорхойлолт